



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙДЫН ТУШААЛ

2020 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/МЗ

Улаанбаатар хот

Арга хэмжээний төлөвлөгөө батлах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 389 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ахмад настны хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний салбар дундын хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Хүн амын хөгжлийн газар /С.Тунгалагтамир/, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Батлагдсан арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Мөнхзул/-т үүрэг болгосугай.


4. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, дүнг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сард багтаан танилцуулахыг Хүн амын хөгжлийн газар /Н.Баярмаа/-т даалгасугай.

САЙД *С. Чинзориг* ЧИНЗОРИГ



151200068

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
сайдын 2020 оны 08 сарын 07
өдрийн А/47 дугаар тушаалын
хавсралт



**АХМАД НАСТНЫ ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

<p>Зорилго</p>	<p>Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах, тэднийг эрүүл урт наслуулах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэхэд оршино.</p>
<p>Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)</p>	<ol style="list-style-type: none">1. Ахмад настан, түүний гэр бүлд үзүүлэх нөлөө:<ol style="list-style-type: none">1.1. Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг эдлэх нийгмийн амьдралд идэвхтэй оролцох боломж бүрдэнэ.1.2. ахмад настны гэр бүлийн орчинд үзүүлэх нөлөөлөл сайжирна.1.3. Ахмад настны эрх ашгийн төлөө ажилладаг ТББ-ын үйл ажиллагаа, идэвх сайжирч, төрийн захиргааны төв болон бүх шатны байгууллага/яам, агентлаг/, орон нутгийн захиргааны байгууллагууд /аймаг, нийслэлийн ЗДТГ/, хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд зэрэг нөлөө үзүүлнэ.2. Эдийн засгийн хөгжил болон захиргааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө:<ol style="list-style-type: none">2.1. Хөтөлбөр хэрэгжсэнээр "Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030"-ийн үр дүнгийн дараах шалгуур үзүүлэлтүүд сайжрахад зэрэг нөлөө үзүүлнэ. Үүнд:<ul style="list-style-type: none">- Хүний хөгжлийн үзүүлэлт- Дундаж наслалт- Ядуурлын түвшин- Орлогын тэгш бус байдлын үзүүлэлт- Ахмад зөвлөхийн үйлчилгээг өргөжүүлснээр эдийн засгийн бүх салбарт бүтээмж нэмэгдэж эдийн засгийн өсөлтөд зэрэг нөлөө үзүүлнэ.2.2. Хөтөлбөр хэрэгжсэнээр захиргааны үйл ажиллагаанд дараах нөлөөлөл үзүүлнэ:<ul style="list-style-type: none">- ахмад настанд үзүүлэх үйлчилгээний хүртээмж чанар сайжирч, бусад иргэдийн хүртэх нийгмийн суурь үйлчилгээнд зэрэг нөлөө үзүүлнэ- ахмад настны эрх хангагдана.3. Хөтөлбөрийн зорилтууд хэрэгжсэнээр урт болон богино хугацаанд нийгмийн хөгжилд дараах нөлөө үзүүлнэ.<ol style="list-style-type: none">1.1. Нийгэм ахмад, дунд, залуу үеэр хуваагдаж бие биеэ үгүйсгэх, зөрчилдөх хандлага багасч, харилцан хүндлэл хүлээн зөвшөөрөл бий болно.1.2. Ахмад настны нийгмийн хамгаалал, нийтийн тээвэр, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээг хүртээмжтэй хүртэх боломж бүрдэж, тэгш бус байдал буурна.<p>Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр үзүүлэх үр нөлөөг дараах байдлаар тодорхойлсон байна:</p><p>Хүмүүсийн амьдралын хэв маягт үзүүлэх нөлөөний талаар:</p><ul style="list-style-type: none">- Аав ээж, ахмад настнаа асран ачийг нь хариулах уламжлалт ёс заншил бэхжинэ.- Ахмад настны талаарх олон нийтийн ойлголт, тэдэнд хандах хандлага өөрчлөгдөж, үл хүндлэх, үл ойшоох үзэл багасна.

		<p>Хүмүүсийн соёлд үзүүлэх нөлөөний талаар: (хамтын итгэл, зан үйл, үнэт зүйл, соёл гэх мэт);</p> <p>- Гэр бүлийн үнэт зүйл, түүний дотор эцэг, эх, үр хүүхдийн ачлал хүндлэлийн ач холбогдол дээшилнэ.</p> <p>Хот суурин газарт нийтийн ашиглалтын зам талбай, гарц, тээврийн хэрэгслийн өртөө, буудал, орон сууц зэрэг байгууламжийн тохь тух, дэд бүтэц сайжирснаар ахмад настан ХБИ, нийт иргэд ая тухтай, аюулгүй орчинд ажиллаж амьдрахад эерэг нөлөө үзүүлнэ.</p>							
Хөтөлбөрийн зорилт 1: Ахмад настны аж байдлыг дээшлүүлж, ядуурлаас хамгаалах.									
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> Ахмад настны орлогын баталгааг сайжруулах. Ахмад настныг ядуурлаас хамгаалах. 							
№	Хөтөлбөрт туссан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжүүлэх байгууллага	
				2020	2021	2022	2023	Хариуцах	Хамтрах
Үйл ажиллагааны чиглэл		1. Ахмад настны орлогын баталгааг сайжруулах.							
5.1.1	Холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актыг хэрэгжүүлэх хүрээнд ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний хүртээмжийн судалгаа хийж, өргөжүүлэх шаардлагатай тусламж, үйлчилгээг тодорхойлох	Судалгаа хийж, санал, зөвлөмж гарсан байна	Судалгаа хийсэн /эсэх	-	-	-	ХНХСИ ¹	ХХҮЕГ ²
		Судалгааны зөвлөмжид үндэслэн ахмад настанд нэн шаардлагатай нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх	Нийгмийн халамжийн тусламж, үйлчилгээнд хамрагдсан ахмад настны хувь хэмжээ өссөн байна	-	Өсөлт 5-аас доошгүй хувь	Өсөлт 10-аас доошгүй хувь	Өсөлт 20-иос доошгүй хувь	ХХҮЕГ	ХХҮЕГ-ын харьяа газар, хэлтэс
5.1.2.	Ахмад настны орлогын баталгааг хангах, ядуурлаас хамгаалах үүднээс малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчдийг тэтгэврийн даатгалд хамрагдах хувь хэмжээг нэмэгдүүлэх	Малчин, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгчдэд тэтгэврийн даатгалын ач холбогдлыг сурталчлах, даатгалд хамруулах чиглэлээр сурталчилгаа, нөлөөллийн ажлыг НДЕГ-ын харьяа газар хэлтсээр дамжуулан тогтмол зохион байгуулах	Малчин, хувиараа болон албан бус салбарт хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэврийн даатгалд хамрагдалтын хувь хэмжээ өссөн байна	Өсөлт 5-аас доошгүй хувь	Өсөлт 10-аас доошгүй хувь	Өсөлт 15-аас доошгүй хувь	Өсөлт 20-иос доошгүй хувь	НДЕГ ³	НДЕГ-ын харьяа Нийгмийн даатгалын газар, хэлтэс

¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын судалгааны институт

² Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

³ Нийгмийн даатгалын ерөнхий газар

5.1.3.	Ахмад настны насан туршийн боловсролд хамрагдах үйл явцыг дэмжих, чадавхжуулах, сургалтад хамруулах замаар шинээр орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх	Ахмад настны эрэлт хэрэгцээнд суурилсан дахин чадавхжуулах сургалтын модуль боловсруулж, батлуулах	Дахин чадавхжуулах сургалтын модуль батлагдсан байна	Сургалтын модуль батлагдсан /эсэх	-	-	-	ХХҮЕГ, МАХХ ⁴	Насан туршийн боловсролын төв, Сургалтын байгууллага
		Дахин чадавхжуулах сургалтад хамрагдаж тэр чиглэлээрээ ажлын байр шинээр бий болгосон эсхүл бизнес эрхэлж байгаа ахмад настныг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт хамруулах замаар дэмжлэг үзүүлэх	Төсөл, хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо/хувь хэмжээ нэмэгдсэн байна	-	5-аас доошгүй хувь	5-аас доошгүй хувь	5-аас доошгүй хувь	Бүх шатны Засаг даргын Тамгын газар, ХХҮЕГ	ХХҮЕГ-ын харьяа газар, хэлтэс
5.1.4.	Малчдын хөдөлмөрийн нөхцөл, амьдралын орчин, бусад хүчин зүйлсийг үндэслэн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох эрхийг хадгалж, хамрагдалтыг нэмэгдүүлэх	Малчдад зориулж хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл, сургалт, нөлөөллийн арга хэмжээг орон нутагт тогтмол зохион байгуулах	40-өөс дээш насны малчдын сургалт, зөвлөгөө нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан хувь хэмжээ нэмэгдсэн байна	20-иос доошгүй хувь	30-аас доошгүй хувь	40-өөс доошгүй хувь	50-иас доошгүй хувь	НДЕГ	Сумдын Засаг даргын Тамгын газар
5.1.5.	Тэтгэвэр барьцаалсан зээлийн хугацааг багасах, хүүг бууруулах замаар ахмад настны орлогыг хамгаалах	Банкуудтай тэтгэвэр барьцаалсан зээлийн хугацааг хязгаарлах, хүүг бууруулах хэлэлцээр хийх, хэрэгжилтийг хангах	Холбогдох шийдвэр батлагдсан байна	Шийдвэр батлагдсан /эсэх	Хэрэгжилт хангагдсан /эсэх	-	-	ХНХЯ ⁵ , НДЕГ	Монгол банк, Арилжааны банкууд
5.1.6.	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын тогтолцоог хөгжүүлэх, хууль эрх зүйн орчин бүрдүүлэх	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хууль эрх зүйн орныг бий болгох хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барих.	Хувийн тэтгэврийн нэмэлт даатгалын хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байна	Хуулийн төслийг боловсруулсан /эсэх	Хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан/ эсэх	-	-	Ажлын хэсэг	ХНХЯ, НДЕГ
Үйл ажиллагааны чиглэл		2. Ахмад настныг ядуурлаас хамгаалах.							

⁴ Монголын ахмадын холбоо

⁵ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

5.1.7.	Ахмад настан олон эх үүсвэр бүхий тэтгэврийн орлоготой байх нөхцөлийг бүрдүүлж, даатгуулагчийг олон жил хөдөлмөрлөж, тасралтгүй шимтгэл төлөхийг дэмжих	Даатгуулагчдад хувийн тэтгэврийн нэмэлт даатгал болон тогтвортой ажиллаж, тасралтгүй шимтгэл төлөхийн ач холбогдлыг сурталчлан таниулах нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах, тэдний хандлагыг өөрчлөх	Нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан даатгуулагчдын хувь хэмжээ өссөн байна	10-аас доошгүй хувийг хамруулсан байх	Суурь түвшингээс 10-аас доошгүй хувь	Суурь түвшингээс 10-аас доошгүй хувь	Суурь түвшингээс 10-аас доошгүй хувь	НДЕГ	ХХҮЕГ, ЭМДЕГ
5.1.8.	Аж ахуйн нэгж, байгууллагыг "Ахмадын сан" байгуулан ажиллуулахыг дэмжих, сангийн үйл ажиллагааг бэхжүүлэх;	Байгууллага, аж ахуйн нэгжид "Ахмадын сан" байгуулах аяныг өрнүүлэх, ахмадын сан байгуулан ажиллуулах журмын хэрэгжилтийг хангах	"Ахмадын сан" байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын тоог нэмэгдүүлсэн байна	20-иос доошгүй хувь	30-аас доошгүй хувь	40-өөс доошгүй хувь	40-өөс доошгүй хувь	МАХХ, салбар, нэгж	Байгууллага, аж ахуйн нэгж
5.1.9.	Хэвтрийн, хөгжлийн бэрхшээлтэй, сэтгэцийн эмгэгтэй зэрэг зайлшгүй байнгын асаргаа шаардлагатай ахмад настны онцлог хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тусгай дэмжлэг үзүүлэх	Асаргааны цогц тусламж, үйлчилгээний суурь судалгааг үе шаттай хийх	Судалгаа хийж, тайлан зөвлөмж гарсан байна	Тайлан зөвлөмж гарсан /эсэх	Зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан /эсэх	-	-	ЭМЯ ⁶	ХНХЯ, Жайка ОУБ
		Судалгаанд үндэслэн асаргааны төв байгуулах	Асаргааны төв-3, жишиг төв-1 шинээр байгуулагдсан байна	Жишиг төв байгуулсан /эсэх	Төв-1 байгуулсан /эсэх	Төв-1 байгуулсан /эсэх	Төв-1 байгуулсан /эсэх	ЭМЯ	ХНХЯ, Жайка ОУБ
5.1.10	Ахмад настны амьдралын чанарын судалгаа хийж, шинэ төрлийн дэмжлэг, тусалцаа, үйлчилгээ нэвтрүүлэх	Ахмад настны амьдралын чанарын судалгаа хийх	Судалгаа хийж, тайлан, зөвлөмж гарсан байна	Холбогдох мэдээллийг цуглуулсан /эсэх	Тайлан зөвлөмж гарсан /эсэх	-	-	ХНХСИ	ХНХЯ, ЭМЯ
		Судалгааны тайлан, зөвлөмжид дэмжлэг, тусалцаа үйлчилгээний төрөл хэлбэрийг нэвтрүүлэх	Шинэ төрлийн дэмжлэг, тусалцаа, үйлчилгээг нэвтрүүлэх шийдвэр батлагдсан байна	-	Төрөл хэлбэрийг тодорхойлсон /эсэх	Нэвтрүүлсэн /эсэх	-	-	ХХҮЕГ
5.1.11	Аймаг, нийслэл, сум,	Бие даан амьдрах	Бие даан	Зорилтот	5-аас дээш	5-аас дээш	5-аас дээш	Бүх	БХБЯ ⁸ ,

⁶ Эрүүл мэндийн яам

⁷ Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар

⁸ Барилга хот байгуулалтын яам

	дүүргүүд ахмад настныг бие даасан орон байртай болгох, орон байрны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг дотоод нөөц бололцронд тулгуурлан хэрэгжүүлэх, түрээсийн орон сууцны хөтөлбөрт хамруулах	хүсэлтэй, өөрийн орон байргүй ахмад настныг орон нутгийн дотоод нөөц боломжид тулгуурлан гэр, орон байраар хангах	амьдрах өөрийн орон байртай ахмад настны тоо/хувь нэмэгдсэн байна.	бүлгийн ахмадуудын судалгаа гаргасан /эсэх	хувь	хувь	хувь	шатны Засаг дарга	ТОСК ⁹ НОСК ¹⁰
		Ахмад настнуудын орон байрны нөхцөлийн сайжруулах арга хэмжээг орон нутгийн дотоод нөөц боломжид тулгуурлан хэрэгжүүлэх	Ахмад настнуудын амьдрах гэр, орон байрны нөхцөл сайжирсан байна	Зорилтот бүлгийн ахмадуудын судалгаа гаргасан /эсэх	5-аас доошгүй хувь	5-аас доошгүй хувь	5-аас доошгүй хувь		
5.1.12	Ахмад настны амьжиргааг дэмжих, ядуурлаас хамгаалах үйл ажиллагаанд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх	Байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ажиллаж байсан болон ажиллаж байгаа ахмад настныхаа амьжиргааг дэмжих санаачилгыг өрнүүлж, тэдний үйл ажиллагааг ахмадын холбоодоор дамжуулан олон нийтэд сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	Санаачлагыг дэмжиж энэ чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо нэмэгдсэн байна	Ажил олгогчдын 10-аас доошгүй хувь арга хэмжээ зохион байгуулсан байх	Өсөлт суурь түвшингээс 10-аас доошгүй хувь	Өсөлт суурь түвшингээс 15-аас доошгүй хувь	Өсөлт суурь түвшингээс 20-иос доошгүй хувь	МАХХ	ХХҮЕГ, МАХХ-ны салбар нэгж
Хөтөлбөрийн зорилт 2: Ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих, урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.									
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> • Эрүүл насжилт, ахмад настны эрүүл мэндийг дэмжих. • Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх. • Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх. 							
№	Хөтөлбөрт туссан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжүүлэх байгууллага	
				2020	2021	2022	2023	Хариуцах	Хамтрах
Үйл ажиллагааны чиглэл		3. Эрүүл насжилт, ахмад настны эрүүл мэндийг дэмжих.							
5.2.1.	Эрүүл насжилт, ахмад настны эрүүл мэндийг дэмжихтэй холбогдуулан хууль эрх зүйн орчны үнэлгээ хийх, холбогдох хууль тогтоомж, бусад эрх зүйн актыг	Эрүүл насжилт, ахмад настны эрүүл мэндийг дэмжих хууль эрх зүйн орчинд үнэлгээ хийх	Үнэлгээ хийж, санал зөвлөмж гарсан байна	Үнэлгээ хийсэн/эсэх	-	-	-	ЭМЯ	ХНХЯ
		Үнэлгээний зөвлөмжид тулгуурлан эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт,	Хуулийн төсөл, үзэл баримтлалыг	Хуулийн үзэл баримтлалыг батлуулсан	Хууль батлагдсан /эсэх	-	-		ХНХЯ, ХЗДХЯ ¹¹

⁹ Төрийн орон сууцны корпораци

¹⁰ Нийслэлийн орон сууцны корпораци

¹¹ Хууль зүй дотоод хэргийн яам

	боловсронгуй болгох арга хэмжээ авах	өөрчлөлт оруулах	боловсруулж, батлуулсан байна	/эсэх						
5.2.2.	Монгол хүний насжилт, ахмад настны эрүүл мэндийн талаарх эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлж, мэдээллийн нэгдсэн сан бий болгох	Насжилт, ахмад настны эрүүл мэнд, чадамжийн чиглэлээрх судалгаа, эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн сан үүсгэх, хэрэглээг дэмжих	Нэгдсэн сан үүсгэж, хэрэглээг дэмжих арга хэмжээг зохион байгуулсан байна	-	Сан хөмрөг үүсгэсэн /эсэх	Нэгдсэн сан	-	ХНХСИ	ЭМЯ, ХНХЯ, ГҮТ ¹² , НЭМҮТ ¹³ , ХХҮЕГ	
5.2.3.	Ахмад настанд зонхилон тохиолддог өвчний үед зайлшгүй хэрэглэх эмийн нэр төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх	Ахмад настны эмийн болон эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүний буруу хэрэглээг бууруулах, зохистой зөв хэрэглээг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	Нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан ахмад настны хувь хэмжээ өссөн байна	20-иос доошгүй хувь	30-аас доошгүй хувь	40-өөс доошгүй хувь	50-иас доошгүй хувь	ЭМДЕГ	ЭМЯ, Эрүүл мэндийн байгуул лагууд	
		Ахмад настанд зонхилон тохиолддог өвчний үед зайлшгүй хэрэглэх эмийн судалгааг шинэчлэн хийж шаардлагатай эмийн үнэ, чанар, нэр төрлийг тодорхойлох, хөнгөлөлттэй эмийн жагсаалтад нэмж оруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх	Хөнгөлөлттэй эмийн жагсаалтыг шинэчлэн баталж, эмийн төрөл, чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна	Судалгаа хийсэн/эсэх	Жагсаалтыг шинэчлэн баталсан /эсэх	-	-		ЭМЯ	
5.2.4.	Ахмад настныг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, шаардлагатай ахмадуудыг эмчилгээ, сувилгаанд хамруулах ажлыг эрүүл мэндийн төвөөр дамжуулан хэрэгжүүлэх, ахмад настанд гэрээр үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх,	Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд ахмад настуудыг танин мэдэхүйн чадварын бууралт, сэтгэцийн өөрчлөлт, эмгэгээс урьдчилан сэргийлэх нэгдсэн үзлэг, шинжилгээг тогтмол зохион байгуулах	Урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоог тогтмол зохион байгуулж, тэдэнд шаардлагатай эмчилгээ, сувилгааг үзүүлсэн байна	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	ЭМЯ	ГҮТ, НЭМҮТ, СЭМҮТ ¹⁴ , Эрүүл мэндийн байгуул лагууд	
		Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ахмад настны гэрээр очиж үзүүлэх	Ахмад настны гэрт очиж үзүүлсэн	Суурь түвшингээс 10-аас	Суурь түвшингээс 15-аас	Суурь түвшингээс 15-аас	Суурь түвшингээс 15-аас			

¹² Геронтологийн үндэсний төв

¹³ Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

¹⁴ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв

	чанарыг сайжруулах	тусламж өргөжүүлэх үйлчилгээг	эмнэлгийн тусламж үйлчилгээний хувь хэмжээ өссөн байна	доошгүй хувь	доошгүй хувь	доошгүй хувь	доошгүй хувь		
5.2.5.	Хэвтрийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмадуудын судалгааг жил бүр нарийвчлан гаргаж, хяналтад авах, гэрээр эмчилгээ, үйлчилгээ үзүүлэх	Сум, өрхийн эрүүл мэндийн төв хэвтрийн өвчтэй, байнгын асаргаа шаардлагатай ахмадуудын судалгаа гаргаж, үйлчилгээ, зөвлөгөөний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх үзүүлэх	Байнгын асаргаа шаардлагатай ахмадуудын судалгаа гаргаж, тусламж үйлчилгээг тогтмол хугацаанд үзүүлж хэвшсэн байна	Сард 2-оос доошгүй удаа	Сард 2-оос доошгүй удаа	Сард 2-оос доошгүй удаа	Сард 2-оос доошгүй удаа	ЭМЯ	ЭМХТ ¹⁵ , Эрүүл мэндийн байгууллагууд
		Олон мэргэжлийн багийн гэрээр очиж үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, тогтмолжуулах	Олон мэргэжлийн багийн тусламж үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо/хувь өссөн байна	10-аас доошгүй хувь	15-аас доошгүй хувь	15-аас доошгүй хувь	20-иос доошгүй хувь		
Үйл ажиллагааны чиглэл		4. Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.							
5.2.6	Ахмад настны эрэлт, хэрэгцээнд суурилсан урт хугацааны олон талт тусламж үйлчилгээг өргөжүүлж хөгжүүлэх, дэвшилтэд технологи, сайн туршлагыг нэвтрүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх	Ахмад настанд үзүүлэх урт хугацааны тусламж үйлчилгээний стратеги батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах	Төлөвлөгөө батлагдаж, хэрэгжсэн байна	Төлөвлөгөө батлагдсан /эсэх	Хэрэгжилт хангагдсан байх	-	-	ХНХЯ, ЭМЯ	ХХҮЕГ, ЭМДЕГ
5.2.7	Урт хугацаанд үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, чанар стандартыг боловсронгуй болгох, хяналт үнэлгээг сайжруулах	Олон улсын стандарт, чиг хандлагад нийцсэн, үндэсний онцлогт тохирсон асрамж, асаргаа, сувилгаа, өдөр өнжүүлэх, өдрийн үйлчилгээний стандартыг бий болгох	Стандарт батлагдсан байна	-	Төсөл боловсруулсан /эсэх	Стандарт батлагдсан /эсэх	-	ХНХЯ, ЭМЯ	ХХҮЕГ, ЭМДЕГ, НДЕГ
5.2.8	Гэрээр болон олон нийтийн оролцоонд	Асаргаа, сувилгаа үзүүлэгчдийг санхүүгийн	Судалгааны тайлан	-	Судалгааны тайлан,	Хэрэгжүүлэх шийдвэр	Хэрэгжилт хангагдсан	ХХҮЕГ, ХНХСИ	ХНХЯ, ЭМЯ,

¹⁵ Эрүүл мэндийн хөгжлийн төв

	түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээ үзүүлэгчдийн хөдөлмөрийн үнэлэмж, нийгмийн хамгааллын асуудлыг судалж шийдвэрлэх	болон бусад төрлийн тусламж, дэмжлэг үйлчилгээнд хамрагдах нөхцөл боломжийг судалж, хэрэгжүүлэх	зөвлөмжид туссан арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр батлагдсан байна		зөвлөмж гарсан /эсэх	батлагдсан /эсэх	/эсэх		ЭМДЕГ
5.2.9	Ахмад настанд тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн чадавхийг нэмэгдүүлэх, асаргаа, сувилгааны чиглэлээр сургалтад хамруулах, мэргэшүүлэх, тэдэнд зориулсан зөвлөгөө, дэмжлэг туслалцааг өргөжүүлэх	Асаргаа сувилгааны чиглэлээр чадавхжуулах сургалт, сурталчилгааг асаргаа үзүүлэгчид, ахмад настууд, сайн дурынханд тохирсон арга хэлбэрээр тогтмол зохион байгуулах, дадлагажуулах	Сургалтад хамрагдаж, мэргэшсэн асаргаа үзүүлэгчдийн тоо/хувь өссөн байна	Сургалт 4 удаа	Сургалт 4 удаа	Сургалт 4 удаа	Сургалт 4 удаа	ЭМЯ, ГҮТ	ЭМХТ, ХХҮЕГ
5.2.10	Урт хугацааны тусламж үйлчилгээний санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр бүрдүүлэх, асаргааны даатгалын эрх зүйн орчин бий болгох	Ахмад настанд үзүүлэх УХТҮ-ний санхүүжилтийн тогтвортой эх үүсвэрийг бүрдүүлэх эрх зүйн орчин бий болгох хүрээнд асаргааны даатгалын хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх	Асаргааны даатгалын хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн байна	-	Судалгаа шинжилгээ хийсэн /эсэх	Үзэл баримтлал, хуулийн төсөл боловсруулсан /эсэх	Төслийг УИХ-д өргөн мэдүүлсэн /эсэх	ЭМЯ, ХНХЯ	ЭМДЕГ, НДЕГ, МАХХ
5.2.11	Түншлэл, хамтын ажиллагаа, олон нийтийн оролцоонд түшиглэн өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох замаар ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний сүлжээ бий болгох	Ахмад настанд үзүүлэх тусламж үйлчилгээний салбар дундын уялдааг хангасан нэгдсэн сүлжээ бий болгох	Салбар хоорондын уялдааг хангасан нэгдсэн сүлжээ бий болсон байна	-	Сүлжээ байгуулах шийдвэр батлагдсан /эсэх	Шийдвэр хэрэгжсэн /эсэх	-	ХХҮЕГ	ХНХЯ, ЭМЯ, НДЕГ, ЭМДЕГ, ГҮТ
Үйл ажиллагааны чиглэл		5. Ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх.							
5.2.12	Холбогдох хууль тогтоомж, бусад эрхийн актыг хэрэгжүүлэх хүрээнд төрөлжсөн асрамжийн үйлчилгээний шинэчлэлийн хөтөлбөр батлуулж, ахмад настанд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг	*Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний шинэчлэлийн хөтөлбөр"-ийг баталж, хэрэгжүүлэх замаар асрамжийн төвд асруулагчдад үзүүлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх	"Ахмад настны төрөлжсөн асрамжийн үйлчилгээний шинэчлэлийн хөтөлбөр" батлагдаж хэрэгжсэн байна	Хөтөлбөр батлагдсан /эсэх	Хөтөлбөрийн хэрэгжилт хангагдсан /эсэх	-	-	ХНХЯ	ХХҮЕГ

	нэмэгдүүлэх								
5.2.13	Ахмад настанд тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагуудын нэр, төрлийг олшруулж, бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох	Ахмад настнуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудын чанар хүртээмжид үнэлгээ хийж, үнэлгээнд үндэслэн тэдний үйл ажиллагааг өргөжүүлж, шинэ төрлийн үйлчилгээ, технологийг үе шаттай нэвтрүүлэх	Үнэлгээ хийж, санал зөвлөмжид тулгуурлан шинэ төрлийн үйлчилгээ, технологийг нэвтрүүлсэн байна	Үнэлгээ хийсэн/эсэх	Үйлчилгээ, технологи нэвтрүүлсэн /эсэх	-	-	ЭМЯ, ГҮТ	Эрүүл мэндийн байгууллагууд
5.2.14	Ахмадуудыг нас, бие бялдрын онцлогт тохирсон сургалт, чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөнд хамруулах	Ахмад настнуудын нас, бие бялдрын онцлогт тохирсон явган аялал, ууланд алхалт зэрэг нэгдсэн арга хэмжээ тогтмол зохион байгуулах замаар чийрэгжүүлэлт, дасгал хөдөлгөөнд тэдний хамруулах, оролцоог хангах	Арга хэмжээг тогтмол зохион байгуулсан байна	2 удаа	2 удаа	2 удаа	2 удаа	Бүх шатны Засаг даргын тамгын газар	МАХХ-ны салбар, нэгж
Хөтөлбөрийн зорилт 3: Ахмад настны чадамжийг дэмжих.									
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрлөх эрхийг хамгаалах Шийдвэр гаргах үйл явцад ахмад настны оролцоог хангах Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах 							
№	Хөтөлбөрт туссан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжүүлэх байгууллага	
				2020	2021	2022	2023	Хариуцах	Хамтрах
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрлөх эрхийг хамгаалах 							
5.3.1	Холбогдох хууль тогтоомж, эрхийн актыг хэрэгжүүлэх хүрээнд ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх	“Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг боловсронгуй болгож хамрах хүрээг өргөжүүлнэ	Хөтөлбөрт хамрагдсан ахмад настны тоо/хувь өссөн байна	Хамрагдалт 0.5-аас дээш хувь	Хамрагдалт 0.8-иас дээш хувь	Хамрагдалт 1.2-оос дээш хувь	Хамрагдалт 1.5-аас дээш хувь	ХЭҮЗ ¹⁶ , ХХҮЕГ	ХХҮЕГ-ын харьяа газар, хэлтэс

¹⁶ Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл

5.3.2	Ахмад настан хөдөлмөрийн хүрээнд ялгаварлалт, мөлжлөгт өртөж байгаа эсэхэд хөндлөнгийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах, хөдөлмөрийн ялгаварлалт, мөлжлөгөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах чиглэлээр ажил олгогч, үйлдвэрчний звлэл болон хөдөлмөрийн байцаагчдын чадавхийг бэхжүүлэх	Ахмад настны хөдөлмөрийн харилцаанд дахь нөхцөл байдалд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж, үнэлгээний дүн, зөвлөмжид үндэслэн шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмжид туссан арга хэмжээг хэрэгжүүлсэн байна	-	Үнэлгээ хийсэн /эсэх	Дүгнэлт, зөвлөмж хэрэгжсэн /эсэх	-	ХАБЭМТ ¹⁷	ХХҮЕГ, ХНХСИ, Судалгааны байгууллага
	Хөдөлмөрийн ялгаварлалт, мөлжлөгийн талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээрх сургалтыг нийгмийн түншүүдэд зориулан зохион байгуулах	Сургалт, нөлөөллийн арга хэмжээний тоо, давтамжийг тогтмол нэмэгдүүлсэн байна	10 удаа	15 удаа	25 удаа	30 удаа	МАХХ	МАХХ-ны салбар нэгж	
5.3.3	Ахмад настны бүтээмж, мэргэшлийн ур чадварыг үнэлэх, тэдний дунд ажил, мэргэжлийн уралдаан зохион байгуулах, мэргэшил, ур чадварыг залууст эзэмшүүлэх зэргээр ахмад настны хөдөлмөрийн бүтээмж, чадамжийн талаарх нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд нөлөөлөх	Ахмад настуудын дунд ажил мэргэжил, ур чадварын тэмцээнийг салбар, мэргэжлийн ангиллаар зохион байгуулах, тэдний ур чадварыг залууст эзэмшүүлэх арга хэмжээг жил бүр зохион байгуулах	Нэгдсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулсан байна	1 удаа	1 удаа	1 удаа	1 удаа	МАХХ	МАХХ-ны салбар нэгж
	Ахмад настны хөдөлмөрийн бүтээмж, чадамжийн талаарх нийгэм дэх хэвшмэл ойлголт, хандлагыг өөрчлөх нөлөөллийн ажилд цахим мэдээллийн сүлжээг өргөнөөр ашиглах /кино, шторк, нэвтрүүлэг, зурагт хуудас/	Контент бэлтгэж, олон нийтэд түгээсэн байна	5-аас доошгүй контент	5-аас доошгүй контент	5-аас доошгүй контент	5-аас доошгүй контент	МАХХ	Хэвлэл мэдээллийн байгуулагууд	
5.3.4	Гэр бүлийн өвчтэй гишүүнийг асрах, ач зээгээ өсгөн хүмүүжүүлэх зэрэг ахмад настны эрхэлж байгаа хөлсгүй хөдөлмөрийг үнэлэмжтэй	Гэр бүлийнхээ байнгын асаргаа шаардлагатай гишүүн болон ахмад настныг асрах, ач зээгээ өсгөн хүмүүжүүлэх зэрэг ахмад настны эрхэлж	Судалгааны дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна	-	Судалгаа хийсэн /эсэх	Дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн /эсэх	-	ХХҮЕГ, ХНХСИ	ХНХЯ, СЯ ¹⁸ , ЭМЯ

¹⁷ Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв

¹⁸ Сангийн яам

	болгох чиглэлээр судалгаа хийх, санал боловсруулах	байгаа хөлсгүй хөдөлмөрийг үнэлэмжтэй болгох чиглэлээр судалгаа хийж, санал боловсруулж танилцуулах								
Үйл ажиллагааны чиглэл		• Шийдвэр гаргах үйл явцад ахмад настны оролцоог хангах								
5.3.5	Төрийн захиргааны төв байгууллага бүр өөрийн салбарын хэмжээнд зөвлөх мэргэжилтнээр ажиллах мэргэжлийн өндөр мэдлэг, үр чадвартай ахмад настны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг мэргэжил, мэргэшлийн чиглэлээр шийдвэр гаргах, хэрэгжүүлэхэд оролцуулах, салбарын албан хаагчдыг чадавхжуулахад зөвлөх, сургагч багшаар ажиллуулах	Төрийн захиргааны төв байгууллага бүр тухайн салбартаа зөвлөх, сургагч багшаар ажиллах хүсэлтэй ахмад мэргэжилтний бүртгэл мэдээллийн сан бүрдүүлж, тогтмол шинэчилж байх	Мэдээллийн сан бүрдүүлж, тогтмол шинэчилсэн төрийн захиргааны төв байгууллагын тоо, хувь тогтмол өссөн байна.	30-аас дээш хувь	50-иас дээш хувь	70-аас дээш хувь	100 хувь	Яам, агентлаг	Яам, агентлагийн дэргэдэх ахмадын хороод	
		Салбарын ахмад настнуудын дунд уулзалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, албан хаагчдыг чадавхжуулахад тэднийг зөвлөх, сургагч багшаар ажиллуулах	Мэдээллийн санд бүртгэлтэй ахмад зөвлөхүүдийн арга хэмжээнд хамрагдсан тоо/ хувь тогтмол нэмэгдсэн байна	10-аас доошгүй хувь	15-аас доошгүй хувь	20-иос доошгүй хувь	30-аас доошгүй хувь			
5.3.6	Төрийн захиргааны төв байгууллага бүр төрийн бодлого, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хянах ажиллагаанд ахмад зөвлөхүүдийг мэргэжлийн чиглэлээр оролцуулах, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрүүдтэй ахмад зөвлөхүүдийг танилцуулах, тэдний санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах	Тухайн салбарт шинээр боловсруулж байгаа бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийн төслийн хэлэлцүүлэг, уулзалтад ахмад зөвлөхүүдийг урьж оролцуулах, тэдний саналыг тусгах	Ирц, оролцоог хангасан байна	Ирцийн 5-аас доошгүй хувь	Ирцийн 5-аас доошгүй хувь	Ирцийн 5-аас доошгүй хувь	Ирцийн 5-аас доошгүй хувь	Яам, агентлаг	Яам, агентлагийн дэргэдэх ахмадын хороод	
		Тухайн салбарын бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг ахмад мэргэжилтнүүдэд танилцуулах арга хэмжээ жилд нэг удаа зохион байгуулж, тэдний санал, зөвлөмжийг тусгах	Зөвлөх, ахмад мэргэжилтнүүдийн ирц, оролцоог хангасан байна	60-аас доошгүй хувь	60-аас доошгүй хувь	60-аас доошгүй хувь	60-аас доошгүй хувь	Яам, агентлаг	Яам, агентлагийн дэргэдэх ахмадын хороод	
5.3.7	Төрийн захиргааны төв байгууллага бүр салбарын ахмад ажилтнуудын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг, онол-	Тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллага нь салбарын ахмад ажилтнуудын зөвлөлдөх уулзалт,	Тухайн салбарын зөвлөх, ахмад мэргэжилтний ирц, оролцоог	60-аас доошгүй хувь	60-аас доошгүй хувь	60-аас доошгүй хувь	60-аас доошгүй хувь	Яам, агентлаг	Яамдын дэргэдэх ахмадын хороод	

	практикийн бага хурал зохион байгуулах замаар ахмад болон залуу үеийн залгамж холбоог хангах	хэлэлцүүлэг, онол-практикийн бага хурлыг жил бүр зохион байгуулах	хангасан байна							
Үйл ажиллагааны чиглэл		• Ахмад настныг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах								
5.3.8.	Нутгийн захиргааны байгууллага нь ахмад настны дунд биеийн тамир, спорт, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөө, шаардагдах хөрөнгийг жил бүр баталж төсөвт тусган хэрэгжилтийг зохион байгуулах	Нутгийн захиргааны байгууллага жил бүр ахмад настны дунд биеийн тамир, спорт, соёл урлагийн арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулах жилийн төлөвлөгөөг баталж, санхүүжилтийг шийдвэрлэн хэрэгжилтийг хангаж ажилласан байх	Спорт, соёл урлагийн арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулсан тоог нэмэгдүүлж, оролцоог хангасан байна	Төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангасан /эсэх	Төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангасан /эсэх	Төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангасан /эсэх	Төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангасан /эсэх	Бүх шатны Засаг даргын Тамгын газар,	Ахмадын хороод Боловсрол, соёл, спортын байгууллагууд	
5.3.9.	Ахмад настны спортын баг, соёл, урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клубийг байгуулах, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх	Ахмад настнуудын спортын баг, соёл урлагийн хамтлаг, сонирхлын бүлэг, клуб байгуулах санаачилгыг дэмжих, арга хэмжээ зохион байгуулахад заал, өрөө тасалгааг үнэ төлбөргүй ашиглуулах	Ахмадуудын хамтлаг, баг, клубын тоог нэмэгдүүлсэн байна	2-оос доошгүй хамтлаг, баг, клуб	2-оос доошгүй хамтлаг, баг, клуб	2-оос доошгүй хамтлаг, баг, клуб	2-оос доошгүй хамтлаг, баг, клуб	Бүх шатны Засаг даргын Тамгын газар, МАХХ	Спорт, соёл, урлагийн байгууллагууд, Ахмадын хороод	
5.3.10	Ахмад настанд зориулан чөлөөт цагийн танхим, өргөө, мэдээллийн төв байгуулж, мэдээллийг амаар, бичгээр, цахимаар, дуут болон дүрс бичлэг зэрэг олон хэлбэрээр авах боломжийг өргөжүүлэх	Ахмадын ордон, өргөө, танхимын үйл ажиллагааг түшиглэн мэдээллийн төв ажиллуулах, зөвлөгөө, мэдээллийн чанар хүртээмжийг нэмэгдүүлэх	Зөвлөгөө, мэдээлэлд хамрагдсан ахмад настнуудын тоо/хувь хэмжээг жил бүр нэмэгдүүлсэн байна	45-аас дээш хувь	50-иас дээш хувь	50-иас дээш хувь	55-аас дээш хувь	Бүх шатны Засаг даргын Тамгын газар	МАХХ, түүний салбар, нэгж	
5.3.11	Чөлөөт цагийн танхим, мэдээллийн төв, албан бус зайлшгүй хэрэгцээт сургалтуудыг тэдний хэрэгцээнд нийцүүлэн зохион байгуулах	Ахмад настны эрэлт хэрэгцээ, хүсэлтэд тулгуурлан тэдний хөгжлийг дэмжих төрөл бүрийн сургалтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх	Сургалтад хамрагдах хүсэлт гаргасан ахмад настнуудын хамрагдсан хувь хэмжээг тогтмол нэмэгдүүлнэ.	-	50-иас доошгүй хувь	60-аас доошгүй хувь	80-аас доошгүй хувь	Бүх шатны Засаг даргын Тамгын газар	Насан туршийн боловсролын төв, Ахмадын байгууллагууд	
5.3.12	Ахмад настан, түүний гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүй, хууль эрх зүй, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн	Аймаг, нийслэл бүр ахмад настан, түүний гэр бүлийн гишүүдэд өгөх зөвлөгөө, мэдээллийн төрөл хэлбэрийг өргөжүүлж,	Нэгдсэн өдөрлөг, арга хэмжээг тогтсон хугацаанд тогтмол зохион	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	Бүх шатны Засаг даргын Тамгын	Холбогдох байгууллагууд	

	зэрэг шаардлагатай зөвлөгөө мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулах	тэднийг мэдээлэл, зөвлөгөөгөөр хангах нэгдсэн өдөрлөг арга хэмжээг тогтмол зохион байгуулах	байгуулж хэвшсэн байна					газар	
Хөтөлбөрийн зорилт 4: Ахмад настны амьдрах орчин нөхцөлийг сайжруулах.									
Үйл ажиллагааны чиглэл		<ul style="list-style-type: none"> • Эцэг эх, үр хүүхдийн ачлал ивээлийн уламжлалт харилцааг бэхжүүлэх • Ахмад, дунд, залуу үеийн залгамж харилцаа, харилцан хүндлэл, хүлээн зөвшөөрлийг бэхжүүлэх • Тэтгэвэрт гарахад бэлтгэх • Орон сууц, нийтийн зориулалттай барилга, байгууламжийн хүртээмж, нөхцөлийг сайжруулах. 							
№	Хөтөлбөрт туссан үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлт				Хэрэгжүүлэх байгууллага	
				2020	2021	2022	2023	Хариуцах	Хамтрах
Үйл ажиллагааны чиглэл		• Эцэг эх, үр хүүхдийн ачлал ивээлийн уламжлалт харилцааг бэхжүүлэх							
5.4.1	Эцэг эх, ахмадаа хүндлэх, асран хамгаалах соёл, хүмүүжил, уламжлалт ёс заншлыг хүүхэд залуучуудад туслах гарын авлага, аудио болон видео хичээл, материал бэлтгэх, хүртээмжийг нэмэгдүүлэх	Эцэг эх, үр хүүхдийн ачлал, харилцан уялдаа холбоо, уламжлалт ёс заншлыг өвлүүлэх талаар гарын авлага, сургамжит өгүүллэг бэлтгэж, аудио, видео хэлбэрт хөрвүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн цахим сүлжээгээр түгээх	Контент бүтээж, цахим сүлжээгээр түгээсэн байна	5-аас цөөнгүй контент	5-аас цөөнгүй контент	5-аас цөөнгүй контент	5-аас цөөнгүй контент	ГБХЗХГ ¹⁹	Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим хуудаснууд
5.4.2	Эцэг, эх, ахмад настантай хамт амьдарч, асарч тэтгэж байгаа гэр бүлд дэмжлэг, туслалцаа үзүүлэх асуудлыг судлан бодлогоор дэмжих	Бие даан амьдрах чадваргүй ахмад настан, аав, ээж, өвөө, эмээгээ асран халамжилж хамт амьдарч байгаа гэр бүлд дэмжлэг туслалцаа үзүүлэх чиглэлээр судалгаа хийх	Судалгаа хийж, дэмжлэг, туслалцааны хэрэгцээг тодорхойлсон зөвлөмж гарсан байна	-	Судалгаа хийж, тайлан зөвлөмж гарсан /эсэх	Зөвлөмжийг хэрэгжүүлсэн /эсэх	-	ХНХСИ	ХНХЯ, ХХҮЕГ
		Эцэг, эх, ахмад настантай хамт амьдарч, асарч тэтгэж байгаа гэр бүлд үзүүлэх дэмжлэгийн төрөл, хэлбэрийг тодорхойлж, батлагдсан хууль, эрх зүйн хүрээнд дэмжих	Зөвлөмжид туссан дэмжлэг, туслалцааг үзүүлэх холбогдох шийдвэр батлагдсан байна	-	-	Шийдвэр батлагдсан /эсэх	Шийдвэрийн хэрэгжилт хангагдсан /эсэх	ГБХЗХГ, ХХҮЕГ	ХНХЯ, ЭМЯ,

¹⁹ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар

5.4.3	Гэр бүлийн гишүүдэд өгөх зөвлөгөө, мэдээллийг өргөжүүлэх	Гэр бүлийн гишүүдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулах ажлыг хөгжлийн төв, хэвлэл мэдээллийн бүх төрлийн хэрэгслээр дамжуулан хүргэх, цахим болон дэвшилтэд технологийг ашиглах	Гэр бүлийн зөвлөгөө, мэдээлэлд хамрагдсан хүний тоо/хувь хэмжээг нэмэгдүүлсэн байна	Өсөлт 10-аас доошгүй хувь	Өсөлт 15-аас доошгүй хувь	Өсөлт 20-иос доошгүй хувь	Өсөлт 25-аас доошгүй хувь	ГБХЗХГ	МҮОНРТ ²⁰ , Хэвлэл, мэдээллийн байгууллагууд
5.4.4	Угийн бичиг хөтлөх, ургийн баяр зохион байгуулахыг дэмжиж удам дамжин орон нутагтаа нэр хүндтэй гэр бүлүүдийг жишээ болгон сурталчлах, алдаршуулах	Ургийн баяр, угийн бичгийн ач холбогдлыг сурталчлан таниулах, орон нутагтаа нэр хүндтэй гэр бүлийн ажил амьдралыг үлгэр жишээ болгон сурталчлан алдаршуулах, нэвтрүүлэг хийж олон нийтэд түгээх	Баримтат кино, нэвтрүүлэг хийж, түгээсэн байна	Нэвтрүүлэг, баримтат кино	Нэвтрүүлэг, баримтат кино	Нэвтрүүлэг, баримтат кино	Нэвтрүүлэг, баримтат кино	ГБХЗХГ,	МҮОНРТ, Хэвлэл, мэдээллийн байгууллагууд
Үйл ажиллагааны чиглэл		• Ахмад, дунд, залуу үеийн залгамж харилцаа, харилцан хүндлэл, хүлээн зөвшөөрлийг бэхжүүлэх							
5.4.5	Ахмад настныг хүндлэх, дэмжиж туслах эцэг эхээ асран тэтгэх үр хүүхдийн үүрэг хариуцлагыг хүүхдэд бага наснаас нь ойлгуулах ажлыг боловсролын салбаргаар дамжуулан зохион байгуулах	Аав ээжээ хайрлах, ахмад настныг хүндлэх дадал, соёлыг эзэмшүүлэх зан үйлийг бага сургуулийн болон цэцэрлэгийн хүүхдэд сургалтын хөтөлбөрөөр дамжуулан олгох, энэ чиглэлийн нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах	Бага сургууль, цэцэрлэг бүр тухайн жилийн сургалтын төлөвлөгөөнд арга хэмжээ тусгаж, хэрэгжүүлсэн байна	2-оос дээш арга хэмжээ	2-оос дээш арга хэмжээ	2-оос дээш арга хэмжээ	2-оос дээш арга хэмжээ	БСШУСЯ ²¹	Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд
5.4.6	Коллеж их, дээд сургуулийн хүмүүнлэгийн ухааны хичээлийн агуулгад насжилтын асуудлыг тусгах	Коллеж, их, дээд сургуулийн хүмүүнлэгийн ухааны хичээлийн агуулгад насжилтын асуудлыг тусгаж хэрэгжүүлэх	Сургалтын хөтөлбөр, агуулгад насжилтын асуудлыг тусгаж батлуулсан байна	-	Сургалтын хөтөлбөрт туссан /эсэх	Хэрэгжилт хангагдсан /эсэх	-	БСШУСЯ	Коллеж, их, дээд сургууль
5.4.7	Ахмад настныг ажилд авахдаа ажлын байран дээр, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахгүй байх ёс зүйг хөдөлмөрийн хамт олны	Байгууллага, аж ахуйн нэгжид ахмад настныг ялгаварлан гадуурхахгүй байх ёс зүйг төлөвшүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг ахмадын байгууллага бүр	Бүх шатны ахмадын байгууллага бүр аж ахуйн нэгж, байгууллагад нөлөөллийн арга	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	2-оос доошгүй удаа	МАХ	МАХ-ны салбар, нэгж

²⁰ Монголын үндэсний олон нийтийн радио телевиз

²¹ Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яам

	дунд төлөвшүүлэх	үе шаттай зохион байгуулах	хэмжээ зохион байгуулсан байна							
5.4.8	Ахмад настны ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, залууст үлгэр дуурайл болох үйлсийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах	Ахмад үеийн ажил хөдөлмөрийн амжилт, түүхэн гавьяа, алдар цолтой ахмадуудын ажил үйлсийг харуулсан баримтат кино, дурсамж, нэвтрүүлэг, уулзалт, ярилцлагыг ТВ-ээр цуврал болгон нэвтрүүлэх, цахим сүлжээгээр түгээх	Дурсамж нэвтрүүлэг, баримтат кино, бэлтгэж, давтамжтайгаар түгээсэн байна	Нэвтрүүлэг, баримтат кино	Нэвтрүүлэг, баримтат кино	Нэвтрүүлэг, баримтат кино	Нэвтрүүлэг, баримтат кино	Нэвтрүүлэг, баримтат кино	МҮОНРТ, ГБХЗХГ	Хэвлэл мэдээллийн бусад байгууллага
Үйл ажиллагааны чиглэл		• Тэтгэвэрт гарахад бэлтгэх								
5.4.9.	Ажил олгогч нь өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настан /ажилтан/-ыг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Ажил олгогч тэтгэвэрт бэлтгэх ажлын хэсэг байгуулж, тухайн онд болон дараагийн 3 жилд хөтөлбөрт хамруулах ахмад настан /ажилтан/-ны бүртгэлийг гаргах, шинэчлэх, тэднийг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх тусгайлсан төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэх	Төлөвлөгөө баталж, хэрэгжүүлдэг ажил олгогчийн тоо/хувь хэмжээ нэмэгдсэн байна	Өсөлт 15-аас доошгүй хувь	Өсөлт 20-иос доошгүй хувь	Өсөлт 25-аас доошгүй хувь	Өсөлт 30-аас доошгүй хувь	НДЕГ, МАХХ	НДЕГ-ын харьяа газар хэлтэс, МАХХ-ны салбар нэгж	
5.4.10	Тухайн ажилтан тэтгэвэрт гарсны дараа аж ахуй болон хувиараа хөдөлмөр эрхлэх хүсэлтэй бол бизнесийн болон ур чадварын сургалтад, сургагч багш зөвлөхөөр ажиллах бол сургагч багш бэлтгэх сургалтад хамруулах, дахин чадавхжуулах сургалтыг ажил олгогчоос зохион байгуулах	Ажил олгогч нь тухайн ажилтны хүсэлт, хэрэгцээ сонирхолд нийцүүлэн мэргэжлийн байгууллагын сургалтад хамруулах, байгууллагынхаа дотоод нөөц боломжид тулгуурлан дахин чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	Хүсэлт гаргасан ахмад настны сургалтад хамрагдсан хувь хэмжээг жил бүр нэмэгдүүлсэн байна	Хамрагдалт 50-иас доошгүй хувь	Хамрагдалт 60-аас доошгүй хувь	Хамрагдалт 70-аас доошгүй хувь	Хамрагдалт 90-ээс доошгүй хувь	ХХҮЕГ, МАХХ	Байгууллага, аж ахуйн нэгж, мэргэжлийн сургалтын байгууллага ууд	
5.4.11	Тэтгэвэрт гарч байгаа ажилтны ажлын амжилтыг үнэлэх, амьдралын замнал, амжилт бүтээлийн талаар сурталчлах, хөдөлмөр алдрыг	Тэтгэвэрт гарч байгаа ажилтны хөдөлмөр алдрыг тэмдэглэх, хамт олноороо хүндэтгэлтэй үдэх, хүндэтгэлийн арга хэмжээг ажил олгогчоос жилд нэг	Арга хэмжээ зохион байгуулсан ажил олгогчийн тоог жил бүр тодорхой хувиар	15-аас доошгүй хувь	20-иос доошгүй хувь	25-аас доошгүй хувь	30-аас доошгүй хувь	МАХХ	Байгууллага, аж нэгжийн ахмадын хороод	

	тэмдэглэх, хамт олноороо хүндэтгэлтэй үдэх зэрэг хүндэтгэлийн арга хэмжээ зохион байгуулах	удаа тогтмол хугацаанд зохион байгуулж хэвших	нэмэгдүүлнэ							
Үйл ажиллагааны чиглэл		• Орон сууц, нийтийн зориулалттай барилга, байгууламжийн хүртээмж, нөхцөлийг сайжруулах								
5.4.12	Ахмад настанд орон сууцыг эрх тэгш хуваарилах, тэдний өвөрмөц хэрэгцээнд зориулан орон сууцыг тоноглож тохижуулах, хүртээмжтэй дэд бүтцийг бий болгох, үр хүүхэд, асран хамгаалагчтайгаа ойр дөхөм байх бололцоог хангах	Түрээсийн болон бусад хэлбэрийн орон сууцны бүртгэл, хуваарилалтыг ахмад настны онцлогт тохирсон хэлбэрээр зохион байгуулах талаар холбогдох журамд нэмэлт өөрчлөлт оруулах	Холбогдох журамд өөрчлөлт оруулж, батлуулсан байна	-	Журамд өөрчлөлт орсон /эсэх	Журмын хэрэгжилт хангагдсан эсэх	-	БХБЯ	НОСК, ТОСК	
		Ахмад настанд хүртээмжтэй дэд бүтцийг бий болгож орон сууцыг тэдний онцлогт тохируулан стандартын дагуу тоноглож тохижуулах ажлыг зохион байгуулах	Дэд бүтцийн хүртээмжид үнэлгээ хийгдэж, санал, зөвлөмжид туссан арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр батлагдсан байна	-	Үнэлгээ хийсэн /эсэх	Дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн /эсэх	-	Аймаг, дүүргийн Засаг даргын Тамгын газар	БХБЯ, ШӨХТГ ²² СӨХ	
5.4.13	Улс орон нутгийн төсөв, дотоодын бусад эх үүсвэр, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр баригдаж байгаа орон сууцны тодорхой хувийг ахмад настанд олгох, сууцны нөхцөлөө сайжруулахад зориулж байх	Улс, орон нутгийн төсөв, дотоодын бусад эх үүсвэр, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр түрээсийн зориулалтаар баригдаж байгаа орон сууцны тодорхой хувийг ахмад настанд сууцны нөхцөлөө сайжруулахад зориулж хуваарилж олгох	Тухай жилд ашиглалтад орсон түрээсийн орон сууцны тодорхой хувийг хуваарилан олгосон байна	15-20 хувь	15-20 хувь	15-20 хувь	15-20 хувь	БХБЯ	Бүх шатны Засаг даргын Тамгын газар, НОСК, ТӨСК	
5.4.14	Орон сууц, гудамж, талбайн нэр, хаяг, дугаарыг стандартын дагуу бичиж байрлуулах, ахмад настны өвөрмөц хэрэгцээнд нийцүүлж өөрчлөх	Орон сууц, гудамж, талбайн нэр, хаяг, дугаарыг стандартын дагуу бичиж байрлуулах, ахмад настны өвөрмөц хэрэгцээнд нийцүүлэн өөрчлөх ажлыг хороо, дүүрэг бүр нэгдсэн журмаар хийж, хэрэгжүүлэх	Стандартын дагуу хаягжилтыг хийж байрлуулах нэгдсэн арга хэмжээ зохион байгуулсан байна	-	Зохион байгуулсан /эсэх	-	-	Бүх шатны Засаг дарга	ШӨХТГ, МХЕГ	

²² Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар

5.4.15	Хот суурин газрын явган хүний зам, нийтийн эзэмшлийн талбайн эвдрэл гэмтлийг засах, халтиргаа гулгааг арилгах, ахмад настанд тохиромжтой сандал сүүдрэвч зэргийг байршуулах	Гадна орчны тохижилт, гудамж талбайн гэрэлтүүлэг, цэвэрлээ, халтиргаа гулгааг арилгах чиглэлээр санаачлага гаргаж ажилладаг шилдэг тохижилттой байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулж, урамшуулах, тэднийг үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах	Шилдэг тохижилттой байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулах, сурталчлах арга хэмжээг зохион байгуулсан байна	Арга хэмжээ 1 удаа	Арга хэмжээ 1 удаа	Арга хэмжээ 1 удаа	Арга хэмжээ 1 удаа	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	Хот тохижилт үйлчилгээний газар ОНӨААТҮГ
5.4.16	Зам талбайн гарц, уулзвар, барилга, байгууламжийн үүд, шат, хонгилыг ахмад настанд ээлтэй аюулгүй, хүртээмжтэй, стандартын дагуу шинэчлэн сайжруулах, хуучин барилгуудад тэдний өвөрмөц хэрэгцээнд тохирсон нэмэлт хэрэгсэл, төхөөрөмж суурилуулах	Зам талбайн уулзвар, гарц, барилга, байгууламжийн үүд, шат, хонгилыг ахмад настанд ээлтэй болгон стандартын дагуу шинэчлэн сайжруулах аяныг өрнүүлж ахмад настанд ээлтэй байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаруулж, тэдний үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах	Аян өрнүүлж ахмад настанд ээлтэй байгууллага, аж ахуйн нэгжийн шалгаруулалтыг зохион байгуулсан байна	1 удаа	1 удаа	1 удаа	1 удаа	ГҮТ, МАХХ	ХНХЯ, ЭМЯ, ЗТХЯ, БХБЯ, ШӨХТГ
		Хуучин орон сууцыг ахмад настны өвөрмөц онцлог хэрэгцээнд тохирсон, стандартад нийцсэн хүртээмжтэй байдлаар засч сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх	Сууц өмчлөгчдийн холбоод хариуцсан орон сууцныхаа тодорхой хувийг тухайн жилд стандартад нийцүүлж засч тохижуулсан байна	10-аас доошгүй хувь	10-аас доошгүй хувь	10-аас доошгүй хувь	10-аас доошгүй хувь	Бүх шатны Засаг даргын Тамгын газар, ШӨХТГ	БХБЯ, МХЕГ ²³ , СӨХ ²⁴
5.4.17	Ахмад настныг нутаг дэвсгэр, захиргааны харьяалал харгалзахгүй хот доторх нийтийн тээврээр үнэ төлбөргүй үйлчлэх нөхцөлийг	Ахмад настны тухай хуулийн 8.1.5-д заасныг хэрэгжүүлж, хот доторх нийтийн тээврээр нутаг дэвсгэр, харьяалал харгалзахгүйгээр үнэ	Хүсэлт гаргасан ахмадуудад хот доторх нийтийн тээврээр үнэ төлбөргүй зорчих картыг	Хэрэгжилт 100 хувь	Хэрэгжилт 100 хувь	Хэрэгжилт 100 хувь	Хэрэгжилт 100 хувь	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	СЯ, ХХҮЕГ, НТҮГ ²⁵

²³ Мэргэжлийн хяналтын ерөнхий газар

²⁴ Сууц өмчлөгчдийн холбоо

²⁵ Нийтийн тээврийн үйлчилгээний газар

	бүрдүүлэх	телбөргүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх Орон нутгийн ахмад настныг нийслэлд нийтийн тээврийн хэрэгслээр үнэ телбөргүй зорчиход шаардагдах төсвийг орон нутгийн төсөвт тусгаж, ИТХ-аар батлуулах, зорчсон тоог үндэслэн нийтийн тээврийн газарт холбогдох дүрэм журамд заасан хугацаанд шилжүүлж хэвших	тухай бүр бүрэн олгосон байна Тухайн жилийн шаардагдах төсвийг ИТХ-аар батлуулж, олгосон байна	Хэрэгжилт 100 хувь	Хэрэгжилт 100 хувь	Хэрэгжилт 100 хувь	Хэрэгжилт 100 хувь	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	СЯ, ХХҮЕГ, НТҮГ
5.4.18	Нийтийн тээврийн хэрэгсэл, үйлчилгээний орчин нөхцөлийг ахмад настны өвөрмөц хэрэгцээнд тохиромжтой, хүртээмжтэйгээр өөрчилж, шинэчлэх	Нийтийн тээврийн хэрэгсэл, үйлчилгээний орчин нөхцөлийг ахмад настанд тохиромжтойгоор өөрчилж тоноглох, шинэчлэх арга хэмжээг үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар дамжуулан үе шаттай сайжруулах	Стандартын дагуу тоногдсон нийтийн тээврийн хэрэгслийн тоо/хувь хэмжээг нэмэгдүүлж, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулсан байна	10-аас доошгүй хувь	10-аас доошгүй хувь	10-аас доошгүй хувь	10-аас доошгүй хувь	ЗТХЯ ²⁶ , НТҮГ ²⁷	Үйлчилгээ үзүүлэгч байгууллага, аж ахуйн нэгж
5.4.19	Насны хяналтын үндэсний индекс тооцох арга зүйг дэлхий нийтийн жишигт нийцүүлэн боловсруулж нэвтрүүлэх	Насжилтын индекс тооцох арга зүйг боловсруулж, нэвтрүүлэх	Арга зүйг батлуулж, нэвтрүүлсэн байна	-	Төсөл боловсруулсан /эсэх	Арга зүй батлагдсан /эсэх	Нэвтрүүлсэн /эсэх	ҮСХ ²⁸ , ХНХСИ	ХНХЯ, ЭМЯ, ГҮТ
5.4.20	Насжилтын талаарх мэдээлэл судалгааг өргөжүүлж, насны хяналтын индекс тооцоход шаардагдах мэдээллийн санг бий болгох	Насны хяналтын индекс тооцоход шаардагдах мэдээллийн нэгдсэн сан бий болгох	Мэдээллийн нэгдсэн сантай болсон байна	Сан хөмрөг бүрдүүлсэн /эсэх	Нэгдсэн сан	-	-	ХНХСИ	ХНХЯ, ЭМЯ, ЗТХЯ, ҮСХ, ГҮТ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ

²⁶ Зам тээврийн хөгжлийн яам

²⁷ Нийтийн тээврийн үйлчилгээний газар

²⁸ Үндэсний статистскийн хороо